



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/96

Бат-Өлзий сум

Харгалзан дэмжигч тогтоох тухай

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5, 25.9, 64 дүгээр зүйлийн 64.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 3 дугаар багийн иргэн Цагаан бөө овогт Эрдэнэ-Очирын Нарансолонгод хуулийн дагуу харгалзан дэмжигч шаардлагатай байгаа тул түүний төрсөн ах болох Цагаан бөө овогт Эрдэнэ-Очирын Баттулгын гаргасан өргөдөл, хүсэлтийн дагуу Э.Нарансолонгийн харгалзан дэмжигчээр Э.Баттулгыг тогтоосугай.

2. Э.Нарансолонгод хувийн хэрэг нээж, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Г.Цэрэндулам) -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН